

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Сэврэй сумын эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: **ӨМА-2026/085/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.audit.mn

Өмнөговь аймаг

2026 он

Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр

Утас: 70533539 Цахим хаяг: usukhbayarts@audit.gov.mn

Аудитын менежер: Т.Хонгорзул

Утас: 70533552 Цахим хаяг: khongorzult@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Шижирболд

Утас: 70533552 Цахим хаяг: umnugovi@audit.gov.mn

Азуре хүлүг аудит ХХК-ийн гүйцэтгэх захирал: Г.Мөнхбаяр

Утас: 70110090 Цахим хаяг: audit@azure.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2026.02.25 № 121

танай _____-ны № _____-т

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН СЭВРЭЙ
СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГА Д.АЛТАНСҮХ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өмнөговь аймгийн Сэврэй сумын эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 3,499.1 мянган төгрөгийн эмнэлгийн тоног төхөөрөмж, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 208,485.0 мянган төгрөгийн түргэн тусламжийн тоноглогдсон автомашин, сумын төсвийн хөрөнгө оруулалтаар 230,027.3 мянган төгрөгийн хуучин эмнэлгийн барилгын засварын ажил хийгдсэн байна.

Аудитын гол асуудал

Эрүүл мэндийн даатгалын сангаас 846,169.6 мянган төгрөгийн гүйцэтгэлийн санхүүжилт авч 90,480.0 мянган төгрөгийн авлагатай ажилласан байна.

Бусад асуудал хэсэг

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан 6 зорилтын хүрээнд 75 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг 96.0 хувийн гүйцэтгэлтэй дүгнүүлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

4626050198

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Данс	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	8,096,205.06	22,591,587.09
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	8,096,205.06	22,591,587.09
3121	Төгрөг	8,096,205.06	22,591,587.09
31211	Төрийн сангийн харилцах	8,096,205.06	22,591,587.09
33	АВЛАГА	43,836,834.76	91,908,693.03
331	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	1,428,677.00
333	Татаас, санхүүжилтийн авлага	43,836,834.76	90,480,016.03
35	БАРАА МАТЕРИАЛ	187,512,371.66	135,671,847.69
351	Түүхий эд материал	64,483,994.01	22,676,057.04
3511	Тусгай зориулалттай материал	28,214,636.31	6,919,940.55
3513	Эм боох материал	36,269,357.70	15,756,116.49
354	Хангамжийн материал	123,028,377.65	112,995,790.65
3541	Бичиг хэргийн материал	3,986,480.00	7,142,134.00
3542	Аж ахуйн материал	7,622,908.50	7,533,817.50
3543	Сэлбэг хэрэгсэл	583,000.00	383,000.00
3546	Хүнсний материал	847,692.00	3,849,600.00
3547	Бусад хангамжийн материал	109,988,297.15	94,087,239.15
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	239,445,411.48	250,172,127.81
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,119,335,647.30	4,369,292,073.83
392	Биет хөрөнгө	4,100,973,647.14	4,350,438,073.83
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,995,077,765.31	3,223,013,026.61
39202	Хуримтлагдсан элэгдэл	(84,942,627.52)	(142,548,350.76)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	119,500,000.00	293,210,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(66,538,333.26)	(88,528,333.26)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	692,424,881.73	715,090,757.55
39206	Хуримтлагдсан элэгдэл	(158,161,038.62)	(200,983,282.64)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	153,871,924.89	155,761,009.53
39208	Хуримтлагдсан элэгдэл	(11,889,204.31)	(27,331,369.96)
39214	Бусад үндсэн хөрөнгө	482,182,794.00	464,967,112.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(20,552,515.08)	(42,212,495.24)
393	Биет бус хөрөнгө	18,362,000.16	18,854,000.00
39301	Програм хангамж	1,750,000.00	492,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,749,999.84)	-
39303	Бусад биет бус хөрөнгө	18,362,000.00	18,362,000.00
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,119,335,647.30	4,369,292,073.83
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	4,358,781,058.78	4,619,464,201.64
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
413	Өглөг	-	-
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	-
51	Засгийн газрын хувь оролцоо	4,358,781,058.78	4,619,464,201.64
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	153,136,301.60	153,136,301.60
51101	Өмч: - төрийн	153,136,301.60	153,136,301.60
512	Хуримтлагдсан үр дүн	4,065,985,161.68	4,326,668,304.54
5121	Өмнөх үеийн үр дүн	4,065,985,161.68	4,065,985,161.68
5122	Тайлант үеийн үр дүн	-	260,683,142.86
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	139,659,595.50	139,659,595.50
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,358,781,058.78	4,619,464,201.64
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,358,781,058.78	4,619,464,201.64

Өмнөговь аймгийн Сэврэй сумын эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

2.2 Аудитад хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	796,256,490.57	1,036,195,586.70
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	98,005,000.00	143,382,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	98,005,000.00	143,382,800.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	698,251,490.57	892,812,786.70
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	698,251,490.57	892,812,786.70
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,739,910,488.59	711,200,014.47
120	Нийтлэг татварын бус орлого	3,739,910,488.59	711,200,014.47
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	200,023,278.00	198,884,351.36
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	172,527,578.00	198,884,351.36
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	27,495,700.00	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	3,491,084,454.40	501,800,587.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	48,802,756.19	10,515,076.11
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,536,166,979.16	1,747,395,601.17
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,046,494,597.29	1,457,503,803.52
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	971,415,383.58	1,409,527,385.01
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	605,955,884.89	772,989,373.14
210101	Үндсэн цалин	409,804,825.94	421,786,128.34
210102	Нэмэгдэл	142,092,558.95	279,826,318.20
210103	Унаа хоолны хөнгөлөлт	18,985,000.00	22,345,000.00
210104	Урамшуулал	35,073,500.00	49,031,926.60
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	74,491,650.52	90,275,242.62
210201	Тэтгэврийн даатгал	49,791,618.46	64,641,456.43
210202	Тэтгэмжийн даатгал	6,717,200.00	10,500,785.16
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,358,600.00	3,704,602.02
210204	Ажилгүйдлийн даатгал	2,902,215.51	2,507,151.48
210205	Эрүүл мэндийн даатгал	10,722,016.55	8,921,247.53
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,267,836.29	93,559,621.49
210301	Гэрэл, цахилгаан	4,225,036.29	10,650,565.49
210302	Түлш, халаалт	22,792,000.00	79,690,600.00
210303	Цэвэр, бохир ус	1,250,800.00	3,218,456.00
2104	Хангамж, бараа материалын зардал	56,301,279.00	55,221,580.00
210401	Бичиг хэрэг	3,655,790.00	6,675,846.00
210402	Тээвэр, шатахуун	34,510,479.00	35,738,305.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,262,100.00	2,609,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	111,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	15,872,910.00	10,086,629.00
2105	Нормативт зардал	52,915,567.85	109,559,261.08
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	36,472,520.85	93,350,819.08
210502	Хоол, хүнс	13,627,992.00	16,208,442.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,815,055.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,509,550.00	25,098,760.00
210604	Урсгал засвар	19,509,550.00	25,098,760.00
2107	Томилолт, зочны зардал	1,346,000.00	3,998,190.00
210702	Дотоод албан томилолт	1,346,000.00	3,998,190.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,735,378.00	4,757,951.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	782,000.00	2,691,703.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	1,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	252,450.00	457,446.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	236,028.00	300,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	77,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	387,900.00	30,400.00
210807	Газрын төлбөр	-	278,402.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	130,892,237.03	254,067,405.68

Өмнөговь аймгийн Сэврэй сумын эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,726,000.00	5,871,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	128,166,237.03	248,195,505.68
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	75,079,213.71	47,976,418.51
2132	Бусад урсгал шилжүүлэг	55,696,000.00	8,082,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	30,216,000.00	8,082,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	25,480,000.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	19,383,213.71	39,894,418.51
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	19,383,213.71	39,894,418.51
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,046,494,597.29	1,457,503,803.52
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	3,489,672,381.87	289,891,797.65
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	26,257,689.98	29,208,654.79
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	7,238,689.98	10,208,654.79
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	19,019,000.00	19,000,000.00
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(26,257,689.98)	(29,208,654.79)
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	3,463,414,691.89	260,683,142.86

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	936,176,877.81	1,188,436,756.79
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	172,527,578.00	198,884,351.36
120	Нийтлэг татварын бус орлого	172,527,578.00	198,884,351.36
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	172,527,578.00	198,884,351.36
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	172,527,578.00	198,884,351.36
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	763,649,299.81	989,552,405.43
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	98,005,000.00	143,382,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	98,005,000.00	143,382,800.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	665,644,299.81	846,169,605.43
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	665,644,299.81	846,169,605.43
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	961,111,154.51	1,167,381,374.76
21	УРСГАЛ ЗАРДАЛ	961,111,154.51	1,167,381,374.76
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	886,031,940.80	1,119,404,956.25
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	605,955,884.89	774,428,050.14
210101	Үндсэн цалин	374,747,609.84	423,224,805.34
210102	Нэмэгдэл	177,149,775.05	279,826,318.20
210103	Унаа хоолны хөнгөлөлт	18,985,000.00	22,345,000.00
210104	Урамшуулал	35,073,500.00	49,031,926.60
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	74,491,650.52	90,275,242.62
210201	Тэтгэврийн даатгал	49,791,618.46	64,641,456.43
210202	Тэтгэмжийн даатгал	6,717,200.00	10,500,785.16
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,358,600.00	3,704,602.02
210204	Ажилгүйдлийн даатгал	2,902,215.51	2,507,151.48
210205	Эрүүл мэндийн даатгал	10,722,016.55	8,921,247.53
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,267,836.29	93,559,621.49
210301	Гэрэл, цахилгаан	4,225,036.29	10,650,565.49
210302	Түлш, халаалт	22,792,000.00	79,690,600.00
210303	Цэвэр, бохир ус	1,250,800.00	3,218,456.00
2104	Хангамж, бараа материалын зардал	48,198,679.00	56,738,485.00
210401	Бичиг хэрэг	3,360,500.00	9,219,100.00
210402	Тээвэр, шатахуун	34,510,479.00	35,738,305.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,262,100.00	2,609,600.00
210404	Ном, хэвлэл	60,000.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	111,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,005,600.00	9,060,280.00
2105	Нормативт зардал	60,859,662.10	66,913,256.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	39,192,286.10	43,720,806.00
210502	Хоол, хүнс	12,890,376.00	19,432,450.00

Өмнөговь аймгийн Сэврэй сумын эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	8,777,000.00	3,760,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	60,608,150.00	22,665,360.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	292,500.00	-
210604	Урсгал засвар	60,315,650.00	22,665,360.00
2107	Томилолт, зочны зардал	1,346,000.00	3,998,190.00
210702	Дотоод албан томилолт	1,346,000.00	3,998,190.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,735,378.00	9,255,951.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	782,000.00	6,801,703.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		1,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	252,450.00	457,446.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	236,028.00	300,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	77,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	387,900.00	30,400.00
210807	Газрын төлбөр	-	278,402.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	-	388,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,568,700.00	1,570,800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,568,700.00	1,570,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	75,079,213.71	47,976,418.51
2132	Бусад урсгал шилжүүлэг	55,696,000.00	8,082,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	30,216,000.00	8,082,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	25,480,000.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	39,894,418.51
213304	Хөрөнгийн	-	39,894,418.51
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	19,383,213.71	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	19,383,213.71	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	(24,934,276.70)	21,055,382.03
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	4,120,000.00	6,560,000.00
	Дотоод эх үүсвэрээр	4,120,000.00	6,560,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	4,120,000.00	6,560,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(4,120,000.00)	(6,560,000.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(29,054,276.70)	14,495,382.03
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	8,096,205.06
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	22,591,587.09

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцоо	Дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан үр дүн	Нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	153,136,301.60	139,659,595.50	602,570,469.79	895,366,366.89
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	153,136,301.60	139,659,595.50	602,570,469.79	895,366,366.89
4	Тайлант үеийн үр дүн	-	-	3,463,414,691.89	3,463,414,691.89
5	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	153,136,301.60	139,659,595.50	4,065,985,161.68	4,358,781,058.78
6	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
7	Тайлант үеийн үр дүн	-	-	260,683,142.86	260,683,142.86
8	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	153,136,301.60	139,659,595.50	4,326,668,304.54	4,619,464,201.64

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн
1	ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,193,348,200.00	949,657,986.92	243,690,213.08
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	143,382,800.00	103,488,381.49	39,894,418.51
132001	Орон нутгийн төсвөөс	143,382,800.00	103,488,381.49	39,894,418.51
134	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,049,965,400.00	846,169,605.43	203,795,794.57
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,049,965,400.00	846,169,605.43	203,795,794.57
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	243,632,500.00	198,884,351.36	44,748,148.64
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	243,632,500.00	198,884,351.36	44,748,148.64
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,436,980,700.00	1,148,542,338.28	288,438,361.72
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,436,980,700.00	1,134,046,956.25	302,933,743.75
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,419,772,700.00	1,125,964,956.25	293,807,743.75
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	916,051,700.00	774,428,050.14	141,623,649.86
210101	Үндсэн цалин	466,399,900.00	423,224,805.34	43,175,094.66
210102	Нэмэгдэл	332,191,800.00	279,826,318.20	52,365,481.80
210103	Унаа хоолны хөнгөлөлт	26,460,000.00	22,345,000.00	4,115,000.00
210104	Урамшуулал	91,000,000.00	49,031,926.60	41,968,073.40
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	128,473,900.00	90,275,242.62	38,198,657.38
210201	Тэтгэврийн даатгал	84,240,900.00	64,641,456.43	19,599,443.57
210202	Тэтгэмжийн даатгал	14,414,300.00	10,500,785.16	3,913,514.84
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,306,800.00	3,704,602.02	1,602,197.98
210204	Ажилгүйдлийн даатгал	5,306,800.00	2,507,151.48	2,799,648.52
210205	Эрүүл мэндийн даатгал	19,205,100.00	8,921,247.53	10,283,852.47
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	133,382,800.00	93,559,621.49	39,823,178.51
210301	Гэрэл, цахилгаан	14,000,000.00	10,650,565.49	3,349,434.51
210302	Түлш, халаалт	111,711,800.00	79,690,600.00	32,021,200.00
210303	Цэвэр, бохир ус	7,671,000.00	3,218,456.00	4,452,544.00
2104	Хангамж, бараа материалын зардал	82,714,000.00	56,738,485.00	25,975,515.00
210401	Бичиг хэрэг	16,000,000.00	9,219,100.00	6,780,900.00
210402	Тээвэр, шатахуун	43,616,500.00	35,738,305.00	7,878,195.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,000,000.00	2,609,600.00	3,390,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	120,000.00	111,200.00	8,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	16,977,500.00	9,060,280.00	7,917,220.00
2105	Нормативт зардал	89,080,800.00	66,913,256.00	22,167,544.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	49,744,000.00	43,720,806.00	6,023,194.00
210502	Хоол, хүнс	27,336,800.00	19,432,450.00	7,904,350.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	12,000,000.00	3,760,000.00	8,240,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	46,000,000.00	29,225,360.00	16,774,640.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	9,500,000.00	3,720,000.00	5,780,000.00
210602	Тавилга	9,000,000.00	2,500,000.00	6,500,000.00
210604	Урсгал засвар	27,500,000.00	23,005,360.00	4,494,640.00
2107	Томилолт, зочны зардал	8,194,000.00	3,998,190.00	4,195,810.00
210702	Дотоод албан томилолт	8,194,000.00	3,998,190.00	4,195,810.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,375,500.00	5,145,951.00	3,229,549.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,535,200.00	2,691,703.00	1,843,497.00

Өмнөговь аймгийн Сэврэй сумын эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000,000.00	1,000,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	750,000.00	457,446.00	292,554.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	300,000.00	300,000.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	508,000.00	-	508,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	32,300.00	30,400.00	1,900.00
210807	Газрын төлбөр	750,000.00	278,402.00	471,598.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	500,000.00	388,000.00	112,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,500,000.00	5,680,800.00	1,819,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,500,000.00	5,680,800.00	1,819,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17,208,000.00	8,082,000.00	9,126,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,208,000.00	8,082,000.00	9,126,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	17,208,000.00	8,082,000.00	9,126,000.00
2	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	1,436,980,700.00	1,134,046,956.25	302,933,743.75
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	8,096,205.06	(8,096,205.06)
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	22,591,587.09	(22,591,587.09)

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 42,198.3 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 42,198.3 мянган төгрөгийн алдааг залрууллаа.

Залруулсан алдаа:

- "Санхүүгийн үр дүнгийн тайлан"-ийн үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материалын орлогын дүн нь "Бараа материалын тайлан"-ийн хандиваар авсан бараа материалын дүнгээс 4.9 мянган төгрөгөөр зөрүүтэй, тайлангийн уялдааг хангаагүй байна.
- "Санхүүгийн байдлын тайлан"-ийн мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдлээс эхний үлдэгдлийг хассан дүн нь "Мөнгөн гүйлгээний тайлан"-ийн нийт цэвэр мөнгөн гүйлгээний дүнгээс 3,256.0 мянган төгрөгөөр зөрүүтэй, тайлангийн уялдааг хангаагүй байна.
- Хувь хүний орлогын албан татварын авлага 1,428.7 мянган төгрөгийг санхүүгийн тайланд бүртгээгүй байна.
- Байгууллагын үйл ажиллагаанд 1 жилээс дээш хугацаанд ашиглагдах үндсэн хөрөнгийн шинжтэй 19,000.0 мянган төгрөгийн ялтсан халаагуурыг бараа материалаар, 17,367.0 мянган төгрөгийн материалыг бөөн дүнгээр бүртгэсэн байна.
- "Санхүүгийн байдлын тайлан" болон бараа материалын тайлангийн тодруулгад хүнсний материал 200.3 мянган төгрөг, эм, боох материал 181.7 мянган төгрөгөөр үлдэгдлийг зөрүүтэй бүртгэсэн байна.
- Тус байгууллагын 7 болон 9 дүгээр саруудад цалингийн зардлыг 681.5 мянган төгрөгөөр, даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэл 78.3 мянган төгрөгөөр нийгмийн даатгалын тайланд дутуу тайлагнасан байна.

Аудитаар нийт 10,083.0 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 450.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 9,633.0 мянган төгрөгийн 2 албан шаардлагыг хүргүүллээ.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 33,504.8 мянган төгрөгөөр бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Д.д	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/					
								Үүнээс		Зөвлөмж			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан	Залруулаагүй	Тоо	Дүн		
1	"Санхүүгийн үр дүнгийн тайлан"-ийн үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материалын орлогын дүн нь "Бараа материалын тайлан"-ийн хандиваар авсан бараа материалын дүнгээс 4.9 мянган төгрөгөөр зөрүүтэй, тайлангийн уялдааг хангаагүй байна.	1	4.9	-	-	1	4.9	1	4.9	-	-	-	-
2	"Санхүүгийн байдлын тайлан"-ийн мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдлээс эхний үлдэгдлийг хассан дүн нь	1	3,256.0	-	-	1	3,256.0	1	3,256.0	-	-	-	-

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Өмнөговь аймгийн Сэврэй сумын эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

	"Мөнгөн гүйлгээний тайлан"-ийн нийт цэвэр мөнгөн гүйлгээний дүнгээс 3,256.0 мянган төгрөгөөр зөрүүтэй, тайлангийн уялдааг хангаагүй байна.												
3	Хувь хүний орлогын албан татварын авлага 1,428.7 мянган төгрөгийг санхүүгийн тайланд бүртгээгүй байна.	1	1,428.7	1	1,428.7	-	-	1	1,428.7	-	-	-	-
4	Байгууллагын үйл ажиллагаанд 1 жилээс дээш хугацаанд ашиглагдах үндсэн хөрөнгийн шинжтэй 19,000.0 мянган төгрөгийн ялтсан халаагуурыг бараа материалаар, 17,367.0 мянган төгрөгийн материалыг бөөн дүнгээр бүртгэсэн байна.	1	36,367.0	-	-	1	36,367.0	1	36,367.0	-	-	-	-
5	"Санхүүгийн байдлын тайлан" болон бараа материалын тайлангийн тодруулгад хүнсний материал 200.3 мянган төгрөг, эм, боох материал 181.7 мянган төгрөгөөр үлдэгдлийг зөрүүтэй бүртгэсэн байна.	1	382.0	-	-	1	382.0	1	382.0	-	-	-	-
6	Тус байгууллагын 7 болон 9 дүгээр саруудад цалингийн зардлыг 681.5 мянган төгрөгөөр, даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэл 78.3 мянган төгрөгөөр нийгмийн даатгалын тайланд дутуу тайлагнасан байна.	1	759.8	-	-	1	759.8	1	759.8	-	-	-	-
	Дүн	6	42,198.3	1	1,428.7	5	40,769.6	6	42,198.3	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Төсвийн хөрөнгөөс 450.0 мянган төгрөгийг спортын тэмцээний шагналд зарцуулсан байна.	1	450.0	1	450.0	-	-	-	-	-	-	-	-
2	Эрүүл мэндийн төвийн эрхлэгч, нягтлан бодогч нар нь 2025 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгдсэн тайланг үнэн зөв, чанартай гарган хуулийн хугацаанд тайлагнан өөрчлөлтгүй дүгнэлт авсан үндэслэлээр 3,118.0 мянган төгрөгийн урамшуулал авсан байна.	1	3,118.0	-	-	1	3,118.0	-	-	-	-	-	-
3	Тайланд хугацаанд 6,515.0 мянган төгрөгийн эмнэлгийн тоног төхөөрөмж, тавилгын худалдаж авалтыг хийхдээ бэлтгэн нийлүүлэгчтэй гэрээ байгуулаагүй байна.	1	6,515.0	-	-	1	6,515.0	-	-	-	-	-	-
Дүн		3	10,083.0	1	450.0	2	9,633.0	-	-	-	-	-	-